

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 дүгээр сарын 11-ний өдөр

дугаар 02/01

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, мөн тус компанийн 2022 оны 02 сарын 08-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн хоёр дах асуудалтай холбогдуулан гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ковид цар тахлын хүнд үеийг харгалзан үзэж, өнгөрсөн жилийнхээ ногдол ашгийг бууруулахгүйгээр, өсгөж 300 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашгийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн дансаар дамжуулан тараахаар тогтоосугай.
4. Ногдол ашиг хуваарилсан тухай тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш 15 өдрийн дотор гаргаж, санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ДНХК-ийн санхүүд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ

Х. НАРАНТУЯА